



БАГШИЙН ҮР ЧАДВАРЫН САНД 4

МЭРГЭЖЛИЙН АНГЛИ ХЭЛ ХИЧЭЭЛИЙГ ЗААХ АРГАЗҮЙН АСУУДАЛД

И.Ариунаа

Abstract:

In the era of highly developed information technology, there is a great chance that learners get information from different sources & study independently.

The facts is more than 500 top universities in the world provide a good opportunity for learners in different parts of the world to study via the internet.

Everytime plenty of source materials such as electronic lessons & handouts are placed on the internet for independent learners of mathematics in various levels by universities, association of math teachers and the individuals.

Without learning mathematical terms but study independently is one of the difficulties those learners face.

Here I present outcomes of the research I did. Teaching occupational English effectively is significantly important to provide a great opportunity for the math learners.

Мэдээлэл технологийн эрчимтэй хөгжлийн үрээр сурагчдын мэдлэг, мэдээлэл олж авах хэрэгсэл улам нэмэгдэж байна. Үүний нэг тод жишээ бол интернэтэд төрөл бүрийн хичээл байрлуулах, онлайнаар их дээд сургуульд суралцах асуудал нээлттэй боллоо. Тухайлбал, дэлхийн 500 гаруй шилдэг сургууль интернэтээр суралцах боломжийг дэлхийн өнцөг булан бүрт амьдарч буй залууст олгоод байна.

Үүний зэрэгцээ математикийг аль ч шатанд бие даан суралцах маш тохиромжтой хичээл, багш нар хичээлдээ ашиглах гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүнийг гадаадын олон их дээд сургууль, математикийн багш нарын холбоо, хувь хүмүүс цаг үргэлж интернэтэд байрлуулсаар байна.

Математикийн мэргэжлийн нэр томъёог үзэлгүйгээр эдгээр хичээлүүдийг судлах асуудал хэлний талаасаа бэрхшээлтэй зүйлийн нэг болж байгаа нь анхаарал татаж байгаа билээ.

Эдгээрээс үзвэл, мэргэжлийн гадаад хэл хичээлийг үр өгөөжтэй зааснаар оюутнуудад маш их боломжийг нээж өгөх ач холбогдолтой.

Математикийн мэргэжлийн нэр томъёог суралцагчдад эзэмшүүлэх сургалт нь сүүлийн

жилүүдэд ихэнх их дээд сургуулийн сургалтын хөтөлбөр төлөвлөгөөнд тусгагдсан байдаг ч хэрэгжилтийн шатандаа үр дүн муутай байдаг тал ажиглагдаж байна.

Даяарчлагдаж буй өнөөгийн нийгэмд дэлхий нийтээрээ хос хэлтэй байх бодлого баримталж буйг соргоогоор тусган авсан "Орчлон" сургууль цэцэрлэгийн цогцолборын хувьд Монгол ба Англи хэлийг үндсэн хэлээ болгож сонгосон байна. Мөн математик, байгалийн ухаан, эрүүл мэнд, дэлхийн түүх, тивүүдийн газарзүй, эдийн засаг зэрэг хичээлийг эх хэл ба англи хэл дээр нь зэрэг судлуулдгаараа онцлог юм. Түүгээр ч зогсохгүй 2005оны 4-р сарын 16-нд байгалийн ухааны улсын анхдугаар олимпиадыг англи хэл дээр зохион байгуулсан байна. 8Б.Болорчимэг багшийн илтгэлд англи хэлийг ямар нэгэн хичээлтэй хослуулан газарзүй англи хэл, түүх англи хэл гэх мэтээр хамтран заах нь алсыг харсан зүйлийн нэг юм. 7

Эдгээрээс үзвэл, математикийн мэргэжлийн англи хэл хичээлийг оюутан суралцагчдад зааснаар тэдэнд эзэмшиж буй мэргэжилдээ дур сонирхолтой, мэдэхгүй чадахгүй зүйлсээ

интернэт болон гадаадын сурах бичиг ашиглан бүрэн шийдвэрлэх боломжийг олгох юм.

Дорнод дээд сургуулийн хувьд Математик англи хэлний дугуйланг 2007 онд, мэргэжлийн англи хэл хичээлийг 2008 онд математикийн ангийн оюутнуудад заахдаа: нэг өдрийн хичээл нь:

- Зорилтоо орчуулах
- Шинэ нэр томъёог орчуулах
- Шинэ сэдвийн хүрээний нэр тодорхойлолт, дүрэм, чанаруудыг орчуулах
- Сурагчид бие даан гарын авлага дээр ажиллах гэсэн бүтэцтэй орчуулах арга барилаар явуулж байна

Энэ хичээл нь Дорнод дээд сургуулийн хувьд анх удаа математикийн ангийн оюутнуудад орж байгаа бөгөөд сургалтын явцад дараах хүндрэлтэй асуудлууд тулгарч байна.

-Оюутнуудын "Би хэлний хичээлд тааруу" гэсэн өөрийн үнэлгээ нь хаалт болох тал зарим оюутан дээр гардаг.

-Оюутнуудын англи хэлний суурь мэдлэг сул байгаа нь хичээлийн агуулгыг өргөжүүлэн заахад удаашралтай байна.

-Математикийг англи хэлээр заахад бэлэн ном сурах бичиг байхгүй тул хичээлийн материалыг бэлтгэхэд багшаас цаг ихээхэн шаардагдаж байсан.

Компьютерийн лабораторийн ачаалал их байдгаас интернэтэд сууж ажиллах боломж хомс байдаг.

Дүгнэлт

Математикийн мэргэжлийн нэр томъёог англи хэл дээр зааж буйн үр дүнд энэ ажил нь үр дүнтэй хийгдсэнээр дараах ажлуудын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхэд хувь нэмэр болох юм. Үүнд:

- Засгийн газраас хэрэгжүүлж буй "Англи хэлний үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилт сайжруулах
- Энэ хичээлийг сайн суралцсаны үрээр оюутнууд ойлгоогүй хичээл болон өөрийн сонирхсон зүйлээ бие даан судлах боломжтой болох:
- Мэргэжлийн англи хэл хичээлийн хувьд одоогоор монголоор хэвлэгдэн гарсан сурах бичиг гарын авлага байхгүй байгаа тул "Англи-Монгол Математикийн сурах

бичиг" , "Математикийн англи монгол нэр томъёоны толь" хийж олны хүртээл болгох:

- Интернэт ашиглан сургалтыг явуулах нь энэ хичээлийн онол практикийг хослуулахын зэрэгцээ оюутанд бодит мэдлэг бүтээх, цаашлаад багш болоод сургалтандаа интернэт болоод гадаадын сурах бичиг ашиглах, бүтээл туурвил хийх:
- Математик, Англи хэлний /орос хэл болон бусад гадаад хэл/ хичээлийн хоорондын интеграцийг гаргаж ирэх:
- Дунд сургуулийн сурагчдад дугуйлангаар математикийн мэргэжлийн нэр томъёог эзэмшүүлэх ажлыг дэлгэрүүлэх:
- Математикийн багш нарт сургалтыг хэрхэн үр ашигтай зохион байгуулах талаар аргазүйн зөвлөмж гаргах:

Номзүй

1. Нэргүй.Н, "Хичээл хоорондын холбоо-багш нарын хамтын ажиллагаа", 1999, Уб.,
2. Mark Dugopolski, "Intermediate Algebra", 2000
3. Prentice Hall, Middle grades Mathematics-1,2,3, 1995
4. "Гадаад хэл заах аргазүйн асуудалд" сэтгүүл, 2004, °5 М.Наранцэцэг, "Орос хэлний сурах бичиг зохиох онол аргазүйн асуудалд"
5. "Гадаад хэл заах аргазүйн асуудалд" сэтгүүл, 2004, °6 Х.Цэдэв "Мэргэжлийн сургалтын толь бичгийн нэгэн хувилбарын тухайд"
6. "Гадаад хэл заах аргазүйн асуудалд" сэтгүүл, 2007, °16
7. Чанартай боловсрол хөгжлийн баталгаа илтгэл 2001, Б.Болорчимэг, "Интернэтийг хичээлийн үйл ажиллагаанд ашиглах нь"
8. www.orchlon.mn сайт
9. Мидас ТББ-ын сайт